

МОНГОЛ, ВЬЕТНАМЫН ХАМТАРСАН АЛБАН МЭДЭЭ

1. Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаярын урилгаар Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгч Нгуен Минь Чиет гэргийн хамт 2008 оны 10 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд Монгол Улсад төрийн айлчлал хийв.

Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр БНСВУ-ын Ерөнхийлөгч Нгуен Минь Чиеттэй албан ёсны хэлэлцээ хийж, Монгол Улсын Их хурлын дарга Д.Дэмбэрэл, Засгийн газрын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг нар БНСВУ-ын Ерөнхийлөгч Нгуен Минь Чиет-д бараалхав. Ерөнхийлөгч Нгуен Минь Чиет Улаанбаатар хотын Хо Чи Мин-ий нэрэмжит 14 дүгээр дунд сургуульд зочлов.

Ерөнхийлөгч Н.Энхбаяр, Ерөнхийлөгч Нгуен Минь Чиет айлчлалын дунгийн тухай Хамтарсан албан мэдээ, Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНСВУ-ын Үйлдвэр худалдааны яам хооронд хамтран ажиллах Санамж бичиг, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Вьетнамын Худалдаа, аж үйлдвэрийн танхим хооронд хамтран ажиллах Санамж бичигт тус тус гарын үсэг зурахад байлцав.

2. Яриа хэлэлцээ найрсаг, дотно уур амьсгалд болов. Хоёр тал тус тусын улс орны нийгэм, эдийн засгийн байдлын талаар мэдээлж, хоёр орны хамтын ажиллагааны харилцааг цаашид хөгжүүлэх талаар санал солилцож, олон улсын болон бүс нутгийн анхаарал татсан асуудлаар санал нэгтэй байв. БНСВУ-ын Ерөнхийлөгч Нгуен Минь Чиет ах дүү монголын ард түмний улс эх орноо бүтээн байгуулж, эдийн засгаа хөгжүүлэх үйл хэрэгтээ ихээхэн амжилт олж буйд баяр хүргээд, Монгол Улсын Засгийн газар, ард түмэн өөрсдийн сонгосон замаар Монгол Улсаа өдрөөс өдөрт цэцэглүүлэн хөгжүүлж, ард түмнийхээ аз жаргалын төлөөх үйл хэрэгтээ цаашид ч их амжилт олно гэдэгт итгэж байгаагаа илэрхийлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр вьетнамын ард түмэн улс орныхоо эдийн засгаа хөгжүүлж, олон улсын интеграцид нэгдэх нээлттэй шинэчлэлийн үйл хэрэгтээ ихээхэн амжилт олж буйг өндрөөр үнэлээд Вьетнамын ард түмэн улс орноо орчин үеийн, аж үйлдвэржсэн, хүчирхэг, хүн ард нь баян чинээлэг, нийгмийн байдлаараа эрх тэгш, ардчилсан, соён гэгээрсэн болгох зорилгоо хэрэгжүүлэх үйл хэрэгтээ цаашид их амжилт олно гэдэгт итгэж байгаагаа илэрхийлэв.

3. Хоёр тал Вьетнам, Монголын хоорондын уламжлалт найрсаг харилцааг чухалчлан үзэж байгаагаа нотолж, Вьетнам, Монголын Найрамдал, хамтын ажиллагааны Гэрээний үзэл санааны дагуу хоёр орны хоорондын хамтын ажиллагааны харилцааг өргөжүүлэн хөгжүүлж шинэ шатанд гаргах, найрамдал, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх

эрх ашгийн үүднээс бүх шатны байгууллага хоорондын яриа хэлэлцээ, төлөөлөгчид солилцоог үргэлжлүүлэх, иргэд хоорондын болон соёл, урлагийн солилцоог нэмэгдүүлэх эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлэв.

4. Хоёр тал бусад салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, ялангуяа худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан технологи, боловсрол, эрүүл мэндийн салбарт хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, хоёр орны бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах хамтарсан үйлдвэр байгуулах, хүн эмнэлэгийн болон малын эм үйлдвэрлэх, ашигт малтмал олборлох, боловсруулах чиглэлээр хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны эрэл хайгуул хийхийг урамшуулан дэмжиж, хоёр орны ард түмэнд бодитой ашиг тус авчрах үр дүнтэй хамтын ажиллагааны харилцааг хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Вьетнам Улсыг Монгол Улсын газрын тос, ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулахад Монгол Улсын төр, засгийн зүгээс дэмжих болно гэдгээ илэрхийлэв.

Хоёр тал Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан технологийн салбарт хамтран ажиллах Вьетнам, Монголын Засгийн газар хоорондын комиссын хүчин чармайлтад баяр хүргэж, энэ оны эцсээр Ханойд хуралдах ЗГХК-ын ээлжит 13 дугаар хурлаар хоёр орны хооронд хамтран ажиллах нөөц боломж бүхий салбаруудад хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх талаар тодорхой шийдвэр гаргах нь зүйтэй гэж үзэв.

Ерөнхийлөгч Нгуен Минь Чиет Вьетнамын Засгийн газар Монгол Улсад нэг мянган тонн цагаан будаа, хэд хэдэн түргэн тусламжийн автомашин бэлэг болгон өгч, мөн ашгийн бус худалдааны нөхцлөөр 20 мянган тонн цагаан будаа нийлүүлэхээр шийдвэрлэснийг мэдэгдэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр Монгол, Вьетнамын ард түмний найрамдлыг билэгдэн тусламж үзүүлж байгаад БНСВУ-ын Ерөнхийлөгч Нгуен Минь Чиет, Вьетнамын Засгийн газар, ард түмэнд чин сэтгэлийн талархал илэрхийлэв.

Хо Чи Мин-ий нэрэмжит 14 дүгээр сургуульд Хо Чи Мин-ий соёлын төвийг байгуулж, Хо Чи Мин-ий хөшөөг босгоход Вьетнамын тал дэмжлэг үзүүлж байгаад Монголын тал баяр хүргэв.

5. Ерөнхийлөгч Нгуен Минь Чиет, Ерөнхийлөгч Н.Энхбаяр олон улсын болон бүс нутгийн байдал хурдан өөрчлөгдөж, бэрхшээл, сорилт учирч буй өнөө үед хоёр тал НҮБ, олон улсын бусад байгууллагад болон олон талт яриа хэлэлцээний хүрээнд үйл ажиллагаагаа уялдуулж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх нь дэлхий дахины болон бүс нутгийн энх тайван, тогтвортой байдал, хамтын ажиллагааны төлөө өөрийн улс

орноо хөгжүүлэх, олон улсын интеграцид нэгдэх явцыг урагшлуулахад чухал ач холбогдолтой байх болно гэдэгтэй санал нэг байв.

Бүс нутгийн олон талт яриа хэлэлцээ, механизмын хүрээнд хоёр талын хамтын ажиллагааг бэхжүүлж, Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагад элсэх Монгол Улсын хүсэл эрмэлзлийг дэмжиж ажиллахаа Вьетнам улс илэрхийлэв.

Монгол Улс 2009 онд болох НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн сонгуульд, Вьетнам улс 2009 онд болох НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын Гүйцэтгэх зөвлөлийн сонгуульд тус тус нэрээ дэвшүүлсэнтэй холбогдуулж, эдгээр сонгуульд харилцан дэмжихээ хоёр тал илэрхийлэв.

Дэлхий дахинд болон бүс нутагт энх тайван, тогтвортой байдлыг хангахад Вьетнам Улс НҮБ-ын Аюулгүй зөвлөлийн байнгын бус гишүүний хувьд бодит хувь нэмрээ оруулж, түүний нэр хүнд олон улсын тавцанд улам бүр дээшилж байгаад Монголын тал баяр хүргэв.

6. Хоёр тал Ерөнхийлөгч Нгуен Минь Чиет-ийн Монгол Улсад хийсэн энэ удаагийн айлчлал хоёр орны ард түмний эрх ашиг, хүсэл эрмэлзэлд нийцэн Вьетнам, Монголын найрсаг харилцаа, уламжлалт хамтын ажиллагааг хөгжүүлэхэд түлхэц өгч, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдал, хамтын ажиллагааг үргэлжлүүлэх үйлсэд чухал хувь нэмэр оруулна гэдэгт санал нэгтэй байлаа.

7. Ерөнхийлөгч Нгуен Минь Чиет Ерөнхийлөгч Н.Энхбаяр болон Монголын ард түмэн Вьетнамын төлөөлөгчдийг халуун дотно, нөхөрсгөөр хүлээн авсанд чин сэтгэлийн талархалаа илэрхийлэв.

БНСВУ-ын Ерөнхийлөгч Нгуен Минь Чиет, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярыг гэргийн хамт тааламжтай цагтаа Вьетнам Улсад айлчлахыг урив. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр урилгыг талархан хүлээн авав. Айлчлалын хугацааг дипломат шугамаар тохиролцохоор болов

2008 оны 10 сарын 30